

ДӨРГӨНИЙ УЦС-ЫН ДАЛАНГИЙН СУУЛТ БОЛОН УСАН САНГ ХООСЛОХ
АЖЛЫН ТЕХНИК ЭДИЙН ЗАСГИЙН ҮНДЭСЛЭЛ БОЛОВСРУУЛАХ АЖЛЫН
ДААЛГАВАР

Техник эдийн засгийн үндэслэл боловсруулахад баримтлах зарчим

1. Техник эдийн засгийн үндэслэл (ТЭЗҮ) нь усан санг хоослох, шороон боомтын суулт, хэв гажилтад дүн шинжилгээ хийх талаар оновчтой шийдвэр гаргахад чиглэгдсэн байх ба үнэн зөв, бодитой мэдээ, мэдээлэл, тооцоо судалгаанд үндэслэгдсэн байна.
2. ТЭЗҮ боловсруулагч хуулийн этгээд нь Усны барилга байгууламжийн технологийн зураг төсөл, тухайн ажлын хүрээнд ТЭЗҮ боловсруулах тусгай зөвшөөрөлтэй байна.
3. ТЭЗҮ боловсруулах судалгааны баг нь төслийн онцлогоос хамаарч хэдэн ч судлаачийн бүрэлдэхүүнтэй байж болох ба тухайн төсөл хэрэгжих салбарын инженер техникийн мэргэжилтнүүдтэй байвал зохино.

ТЭЗҮ-ээр хийгдэх ажлын жагсаалт

1. Усан санг хоосолсны дараа УЦС-ын үйл ажиллагааг хэвийн явуулах эдийн засгийн үр ашгийг тооцсон байх.
2. Шороон боомт, станцын барилгын суулт, тэнхлэгийн дагуугийн болон хөндлөн шилжилт, хэв гажилтыг мэргэжлийн байгууллагаар хэмжүүлж, өмнөх жилүүдэд хийгдсэн хэмжилтийн үр дүнтэй харьцуулан, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээг төлөвлөх.
3. Хар Ус нуурыг бүрдүүлэгч Ховд, Буянт, Цэнхэр, Чонохарайх голуудын урсацын судалгаа
4. Хар Ус нуур, Хар нуур, Дөргөн нууруудын усны түвшний өөрчлөлт, ууршилтыг судлах.
5. Хар Ус нуур болон усан сангийн усны түвшний хамаарал, Чонохарайх гол ба Хар Ус нуурын хамаарлыг тодорхойлох
6. Усан сангийн шүүрэлт, ууршилт, хагшаасны судалгаа
7. Усан сан хоосолсны дараа хийгдэх ажлын төлөвлөгөөг боловсруулах, засвар хийх тоноглолуудын судалгаа, засварт шаардлагатай тоног төхөөрөмж, сэлбэг

хэрэгслийн үнийн санал авах, худалдан авалт хийх, суурилуулах зэрэг хугацааг тодорхойлох.

8. Усан сангийн ёроолын зураглал хийж, хагшаасны хэмжээг тодорхойлох.
9. Усан санг хоосолсны дараа усан сангийн ёроолд тогтсон хагшаасны хатах хугацаа, зэгс болон хагшаасыг цэвэрлэх тоног төхөөрөмж, машин механизм, ажиллах хүчний тооцоо, хугацаа, календарчилсан төлөвлөгөө гаргах.
10. Загас гаргуурын хаалтны засвар үйлчилгээ, хаалтны өмнө хуримтлагдсан зэгс, зэгсний үндэс, хагшаасыг зайлуулах машин механизм, ажиллах хүчний судалгаа, төлөвлөгөөг графикаар гаргах.
11. Усан санг хоослох, дүүргэх урсац тохируулгын тооцоо хийх, энэ хугацаанд ашиглах цахилгаан эрчим хүчний хэрэглээ, үйлдвэр зогсох хугацаанд тасалдах цахилгаан эрчим хүчний үйлдвэрлэлтийн төлөвлөгөөг хэдийд, хэрхэн нөхөж үйлдвэрлэх талаар нарийвчлан тооцоолсон байх.
12. Үйлдвэр зогссоноос ажиллаж эхлэх хүртэл бүх хугацаанд хийгдэх ажил, засвар үйлчилгээ, машин механизмын зардал, ажилчдын цалин, зардал, ажилчдын ажиллах цагийн хуваарь, үйлдвэрлэлтийн төлөвлөгөөний графикийг нэг бүрчлэн гаргаж тооцсон байх.
13. Станц зогсох хугацаанд Чонохарайх голыг боломжит урсацаар нь доод хашиц руу экологийн тэнцвэрийг алдагдуулахгүйгээр өнгөрүүлж байхаар тооцох.
14. Байгаль орчинд нөлөөлөх сөрөг нөлөөллийг бууруулах төлөвлөгөө боловсруулах.

Ажил гүйцэтгэх үеийн техникийн шаардлага

1. Захиалагч нь гүйцэтгэгчид шаардлагатай мэдээ мэдээлэл, ажлын төлөвлөгөө, заавар зөвлөмжийг өгч хамтарч ажиллана.
2. Гүйцэтгэгч нь ажил гүйцэтгэхэд шаардлагатай багаж хэрэгсэл, тоног төхөөрөмж, хэрэглэх түлш шатахууны зардлыг бэлдэж ажлын талбар дээр ирэх бөгөөд шаардлагатай тохиолдолд захиалагчаас машин, тоног төхөөрөмжийг байгууллагын удирдлагын зөвшөөрлөөр ашиглаж болно.
3. Ажил гүйцэтгэхэд шаардлагатай багаж хэрэгсэл, тоног төхөөрөмжийг гүйцэтгэгч тал бүрэн хариуцаж, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн дүрмийг баримталж ажиллана.

ХЯНАСАН: АШИГЛАЛТЫН АЛБАНЫ ДАРГА
БОЛОВСРУУЛСАН: УББ-ИЙН ИНЖЕНЕР



Б.СҮХНАРАН
Д.МЯГМАРСҮРЭН